

**“ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 01 дүгээр
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”, 42 дугаар зүйлийн 42.2-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”, 51 дүгээр зүйлийн 51.3-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус Улсын Их Хурал батлахаар хуульчилсан.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтад Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмуудын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно.

Хууль санаачлагч журмын төслүүдэд дараах харилцааг зохицуулахаар тусгасан байна. Үүнд:

1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төсөлд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн нэгжийн иргэдийн саналыг авах ажлыг зохион байгуулах, иргэдийн саналыг авах, дүнг мэдээлэх үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлыг;

2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журмын төсөлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл, эгүүлэн татах асуудлыг санаачлах, эгүүлэн татах санал хураалт зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлыг;

3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журмын төслөөр Зөвлөл нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан

хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулахтай холбоотой болон бусад асуудлыг зохицуулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд заасан гурван журмыг батлах хэрэгцээ, шаардлага, хугацааны талаар, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах чиг үүргийн биелэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад заасан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийн талаар төсөл боловсруулах ажлын хэсэгт тухайн нэгжийн төлөөллийг хэрхэн сонгож оруулах талаар, тогтоолын төслийн хоёрдугаар хавсралтын иргэдийн Хурлын Төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах асуудлаар санал хураалтыг товлон зарлах болон сонгогчдын нэрсийн жагсаалтыг үйлдэхтэй холбоотойгоор журамд заасан хугацаа нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байгаа талаар, эгүүлэн татах асуудлаар гаргасан саналд хяналт тавих, санал хураалт явуулах зардлын эх үүсвэр, санал хураалтын хороог байгуулах бүрэлдэхүүний зохицуулалтын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Н.Энхболд нар “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан батлах, “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”-ын төслүүдийн зарим зохицуулалтыг нарийвлах, тодруулах шаардлагатай талаар саналаа илэрхийлсэн болно.


“Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх буюу 70 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Ж.МӨНХБАТ